



ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДААС 2022-2025 ОНУУДАД БИЧИЖ ОЛГОСОН ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ЭМНЭЛГИЙН ХУУДАСНЫ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

АГУУЛГА:

Ерөнхий мэдээлэл	2
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудасны бичилт олголтын ерөнхий үзүүлэлтүүд	2
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийг насны бүлгээр ангилсан үзүүлэлт	3
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийг хүйсээр ангилсан үзүүлэлт	3
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийг эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан байдлаар ангилсан үзүүлэлт	3
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсаар олгосон тэтгэмжийн мөнгөн дүнгийн үзүүлэлт	4
Хөдөлмөрийн чадвар түр алдсан шалтгаанаар / өвчний бүлгээр/	5
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийн шалтгаан болж буй өвчний бүлгийг бусад үзүүлэлттэй харьцуулсан байдал	5
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийн шалтгаан болж буй өвчний бүлэг ба насны бүлгээр харьцуулсан үзүүлэлт	5
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийн өвчний бүлэг болон насны бүлгээр харьцуулсан үзүүлэлт ...	6
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийн өвчний бүлэг ба тэтгэмжийн мөнгөн дүнтэй харьцуулсан үзүүлэлт	7
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудасны бичилт олголтоор тэргүүлж буй эдийн засгийн салбарууд	8
Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсан шалтгаан ба эдийн засгийн ангиллын харьцуулсан үзүүлэлт	8
Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн мөнгөн дүнгийн үзүүлэлтийг эдийн засгийн ангилалтай харьцуулсан үзүүлэлт	9
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийн эдийн засгийн ангилал ба өвчний бүлгийн харьцуулсан үзүүлэлт	10
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудасны бичилт олголттой холбоотой зарим үзүүлэлтүүд	11
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичиж олгосон давтамж	12
Эмнэлгийн хуудас бичиж олгосон тоогоор тэргүүлж буй эрүүл мэндийн байгууллагууд	12
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн давтамжаар хамгийн өндөр 20 иргэн ба ажил олгогчийн нэр	12
Эмнэлгийн хуудас бичиж олгосон эмч ба ажиллаж буй эрүүл мэндийн байгууллага	13
Дүгнэлт	14
Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал	14

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДААС 2022-2025 ОНУУДАД БИЧИЖ ОЛГОСОН ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ЭМНЭЛГИЙН ХУУДАСНЫ ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Улаанбаатар хот

2026.01.14

Нэг. Ерөнхий мэдээлэл

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, эрүүл мэндийн сайдын 2023 оны А/177, А/433 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам” зэрэг эрхзүйн баримт бичгийг үндэслэн ердийн өвчин, ахуйн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогод өртсөний улмаас эрүүл мэндийн байгууллагаас тусламж үйлчилгээ авсан даатгуулагч хүнд олгосон эмнэлгийн хуудсаар нийгмийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг олгож байна.

Эмнэлгийн хуудасны бичилт, олголтыг 2022 оноос эхлэн цахим хэлбэрт шилжүүлснээр бодит өгөгдөлд тулгуурлан дүн шинжилгээ хийх боломж бүрдсэн ба 2022-2025 оны 10 дугаар сар хүртэлх хугацааны нийгмийн даатгалын байгууллагын цахим мэдээллийн санд тулгуурлан судлан үзэхэд 2000 гаруй эрүүл мэндийн байгууллагаас давхардаагүй тоогоор 234076 даатгуулагчид 505091 эмнэлгийн хуудсыг бичиж, олгон ажил олгогч байгууллагаас 134.7 тэрбум, нийгмийн даатгалын сангаас 123.6 тэрбум нийт 258.3 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг олгосон байна.

Энэхүү судалгаанд хийсэн дүн шинжилгээг эрүүл мэндийн байгууллагуудаас бичиж олгосон хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудасны мэдээлэлд тулгуурлан өвчлөлийн бүтэц, нас, хүйсийн ялгаа, эдийн засгийн салбарын ангилал, тэтгэмжийн санхүүгийн ачааллыг тоон болон харьцуулсан аргаар судалж үзэв.

Дүн шинжилгээний зорилго нь хөдөлмөрийн чадвар түр алдалтад нөлөөлж буй гол хүчин зүйлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, нийгмийн даатгалын сангийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого, зохицуулалт, шийдвэр гаргалтад шаардлагатай мэдээллийн суурийг бүрдүүлэхэд оршино.

Дүн шинжилгээний үр дүнг нас, хүйс, өвчний бүлэг, эдийн засгийн салбарын ангилалаар задлан харуулж, эрсдэл өндөртэй бүлэг, салбаруудыг тодорхойлон бодлогын түвшний дүгнэлт, санал боловсруулахад ашиглах боломжтойгоор боловсруулав.

Хоёр. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудасны бичилт олголтын ерөнхий үзүүлэлтүүд


2.1 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийг насны бүлгээр ангилсан үзүүлэлт

2022–2025 онд нийт 505091 удаагийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичигдсэн бөгөөд үүний 62.4 хувь нь 31–50 насанд ногдож байна. Үлдсэн насны бүлгүүдийн эзлэх хувь нь үүнээс доогуур түвшинд байна. (Хүснэгт 1)

Эмнэлгийн хуудасны бичүүлсэн даатгуулагчийн насны бүлгээр

(Хүснэгт 1)

Насны бүлэг	2022 он	2023 он	2024 он	2025 он	Нийт
17–20	1 (0.0%)	4 (0.0%)	65 (0.0%)	247 (0.2%)	317 (0.1%)
21–30	10,964 (9.8%)	15,538 (11.3%)	19,516 (13.5%)	17,369 (15.5%)	63,387 (12.5%)
31–40	37,633 (33.7%)	43,127 (31.5%)	47,061 (32.6%)	37,378 (33.3%)	165,199 (32.7%)
41–50	32,580 (29.2%)	40,498 (29.6%)	43,357 (30.0%)	33,729 (30.1%)	150,164 (29.7%)
51–60	26,097 (23.4%)	32,846 (24.0%)	30,573 (21.2%)	21,231 (18.9%)	110,747 (21.9%)
61–70	4,319 (3.9%)	4,781 (3.5%)	3,619 (2.5%)	2,080 (1.9%)	14,799 (2.9%)
71-ээс дээш	133 (0.1%)	153 (0.1%)	108 (0.1%)	84 (0.1%)	478 (0.1%)
Нийт	111,727 (100%)	136,947 (100%)	144,299 (100%)	112,118 (100%)	505,091 (100%)



2.2 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийг хүйсээр ангилсан үзүүлэлт

Хүйсийн ангиллаар авч үзвэл хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудасны бичилт, олголтод эмэгтэйчүүдийн эзлэх хувь бүх онуудад өндөр байна.


2022–2025 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд нийт бичигдсэн эмнэлгийн хуудасны 293701 буюу 58.1 хувийг эмэгтэйчүүдэд, 211390 буюу 41.9 хувийг эрэгтэйчүүдэд бичиж олгосон байна.

2022-2024 онуудад эмэгтэйчүүдийн эзлэх хувь 57.3–58.8 хувь, эрэгтэйчүүдийнх 41.2–42.7 хувийн түвшинд хэлбэлзэж, хүйсийн харьцаа хэвээр хадгалагдсан байна. (Хүснэгт 2)

Эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийн хүйсээр

(Хүснэгт 2)

Хүйс	2022 он	2023 он	2024 он	2025 он	Нийт
Эмэгтэй	65,682 (58.8%)	80,118 (58.5%)	83,670 (58.0%)	64,231 (57.3%)	293,701 (58.1%)
Эрэгтэй	46,045 (41.2%)	56,829 (41.5%)	60,629 (42.0%)	47,887 (42.7%)	211,390 (41.9%)
Нийт	111,727 (100%)	136,947 (100%)	144,299 (100%)	112,118 (100%)	505,091 (100%)




2.3 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийг эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан байдлаар ангилсан үзүүлэлт

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний ангилалаар авч үзэхэд хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудасны бичилт, олголтод амбулаторийн тусламж зонхилж байгаа бөгөөд 2022–2025 оны хугацаанд жил бүр нийт дүнгийн 51.0–64.5 хувийг бүрдүүлж байна. Үүний зэрэгцээ хэвтэн эмчлүүлсэн эмнэлгийн хуудасны хувь 2022–2024 онд дараалан өсөж, 35.5 хувиас 48.9 хувь хүртэл нэмэгдсэн нь тухайн хугацаанд нийт эмнэлгийн хуудасны бичилт, олголт нэмэгдэхэд нөлөөлсөн байна. (Хүснэгт 3)

Эмнэлгийн хуудасны бичилт, олголтын тусламж
үйлчилгээний хэлбэр

(Хүснэгт 3)

Эмнэлгийн тусламж үйлчилгээний ангилал	2022 он	2023 он	2024 он	2025 он
Амбулаториор	72,038 (64.5%)	73,441 (53.6%)	73,643 (51.0%)	60,740 (54.2%)
Өдрийн эмчилгээ	–	–	133 (0.1%)	108 (0.1%)
Хэвтэн эмчлүүлсэн	39,689 (35.5%)	63,506 (46.4%)	70,523 (48.9%)	51,270 (45.7%)
Нийт	111,727 (100%)	136,947 (100%)	144,299 (100%)	112,118 (100%)



2.4 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсаар олгосон
тэтгэмжийн мөнгөн дүнгийн үзүүлэлт


Тэтгэмжийн нийт дүн 2022 онд 41370.7 сая төгрөгөөс 2024 онд 80821.1 сая төгрөг болж өссөн нь эмнэлгийн хуудасны тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

Санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд дурьдсан хугацаанд ажил олгогчоос олгосон тэтгэмжийн хувь 50.7–53.4 хувийн хооронд, нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэмжийн хувь 46.6–49.3 хувийн хооронд хэлбэлзэж, хоёр эх үүсвэрийн харьцаа ойролцоо түвшинд хадгалагдаж байна. Нийт дүнгээр авч үзвэл 2022–2025 онд олгосон тэтгэмжийн 52.2 хувь нь ажил олгогчоос, 47.8 хувь нь нийгмийн даатгалын сангаас санхүүжсэн байна.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсаар олгосон
тэтгэмжийн мөнгөн дүнгээр

(Хүснэгт 4)

Он	Эмнэлгийн хуудасны тоо (%)	Нийт тэтгэмжийн дүн (сая ₮)	Нийгмийн даатгалын сангаас (сая ₮, %)	Ажил олгогчоос (сая ₮, %)
2022	111,727 (22.1%)	41,370.7	19,275.0 (46.6%)	22,095.7 (53.4%)
2023	136,947 (27.1%)	63,595.9	31,359.8 (49.3%)	32,236.1 (50.7%)
2024	144,299 (28.6%)	80,821.1	37,941.9 (46.9%)	42,879.2 (53.1%)
2025	112,118 (22.2%)	72,570.1	35,030.1 (48.3%)	37,539.9 (51.7%)
Нийт	505,091 (100%)	258,357.9	123,606.9 (47.8%)	134,750.9 (52.2%)



2.5 Хөдөлмөрийн чадвар түр алдсан шалтгаанаар / өвчний бүлгээр/

Нийт бичигдсэн эмнэлгийн хуудасны 111827 нь гэмтэл, осолд хамаарч, 22.1 хувийг эзэлж байна. Гэмтэл, ослын шалтгаант эмнэлгийн хуудасны эзлэх хувь 2022–2025 онд 17.5–24.0 хувийн хооронд хэлбэлзэж, бусад өвчний бүлгүүдтэй харьцуулахад өндөр түвшинд байна.

Хоол боловсруулах эрхтэн, шээс бэлгийн зам, амьсгалын замын өвчин болон зүрх судасны өвчнээс шалтгаалсан хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас нь жил бүр 8–11 хувьтай байгаа нь харьцангуй өндөр байна. Эдгээр өвчнүүд жил бүр ойролцоо түвшинд байна.

Ерөнхийд нь авч үзвэл өвчний бүлгийн бүтэц 2022–2025 онд мэдэгдэхүйц өөрчлөгдөөгүй бөгөөд гэмтэл, осол болон зүрх судас, хоол боловсруулах, бөөр, амьсгалын замын өвчнүүд зонхилж байна.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийн өвчний бүлгээр

(Хүснэгт 5)

Өвчний бүлэг	2022 он	2023 он	2024 он	2025 он	Нийт
Амьсгалын зам	8,374 (7.5%)	13,767 (10.1%)	13,929 (9.7%)	11,266 (10.1%)	47,336 (9.4%)
Арьс	2,658 (2.4%)	3,807 (2.8%)	4,146 (2.9%)	2,982 (2.7%)	13,593 (2.7%)
Бусад	22,058 (19.7%)	1,121 (0.8%)	252 (0.2%)	208 (0.2%)	23,639 (4.7%)
Гэмтэл, осол	19,582 (17.5%)	30,887 (22.6%)	34,458 (23.9%)	26,900 (24.0%)	111,827 (22.1%)
Дотоод шүүрэл	1,327 (1.2%)	2,153 (1.6%)	2,164 (1.5%)	1,490 (1.3%)	7,134 (1.4%)
Жирэмслэлттэй холбоотой	6,747 (6.0%)	9,257 (6.8%)	10,016 (6.9%)	8,712 (7.8%)	34,732 (6.9%)
Зүрх судас	8,924 (8.0%)	13,694 (10.0%)	14,674 (10.2%)	10,460 (9.3%)	47,752 (9.5%)
Мэдрэл	5,287 (4.7%)	8,714 (6.4%)	8,514 (5.9%)	6,247 (5.6%)	28,762 (5.7%)
Нүд, чих	1,682 (1.5%)	2,319 (1.7%)	2,581 (1.8%)	1,904 (1.7%)	8,486 (1.7%)
Сэтгэц	1,550 (1.4%)	1,984 (1.4%)	2,529 (1.8%)	2,035 (1.8%)	8,098 (1.6%)
Тодорхойгүй шинж	41 (0.0%)	65 (0.0%)	94 (0.1%)	73 (0.1%)	273 (0.1%)
Хавдар, цусны өвчин	4,787 (4.3%)	6,492 (4.7%)	6,578 (4.6%)	5,649 (5.0%)	23,506 (4.7%)
Халдварт өвчин	1,860 (1.7%)	2,998 (2.2%)	3,017 (2.1%)	2,662 (2.4%)	10,537 (2.1%)
Хоол боловсруулах	9,095 (8.1%)	13,788 (10.1%)	14,481 (10.0%)	10,830 (9.7%)	48,194 (9.5%)
Шээс, бэлгийн	10,804 (9.7%)	15,389 (11.2%)	14,807 (10.3%)	11,495 (10.3%)	52,495 (10.4%)
Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой	1,575 (1.4%)	2,749 (2.0%)	3,266 (2.3%)	2,716 (2.4%)	10,306 (2.0%)
Яс, булчин	5,376 (4.8%)	7,763 (5.7%)	8,793 (6.1%)	6,489 (5.8%)	28,421 (5.6%)
Нийт	111,727 (100%)	136,947 (100%)	144,299 (100%)	112,118 (100%)	505,091 (100%)

Гурав. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийн шалтгаан болж буй өвчний бүлгийг бусад үзүүлэлттэй харьцуулсан байдал


3.1 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийн өвчний бүлэг ба насны бүлгээр харьцуулсан үзүүлэлт

Өвчний бүлэг болон насны ангиллыг харьцуулан үзэхэд гэмтлийн өвчин нийт бичигдсэн эмнэлгийн хуудасны бүх насанд харьцангуй өндөр хувийг эзэлж байна. Ялангуяа 17–20 насанд 40.1 хувьд хүрсэн нь анхаарал татаж байна. Амьсгалын замын өвчин залуу насанд илүү өндөр хувьтай байж нас ахих тусам буурсан, харин зүрх судасны өвчин 41–50 наснаас эхлэн нэмэгдэж, эзлэх хувь нь өсөх чиг хандлага ажиглагдаж байна. Яс, булчингийн болон мэдрэлийн өвчний хувьд 31–50 насанд харьцангуй өндөр хувь ажиглагдаж байгаа бол арьсны өвчин, сэтгэцийн өвчин, дотоод шүүрлийн өвчин, халдварт өвчин бүх насанд бага хувийг эзэлж байна. (Хүснэгт 2)

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийн өвчний бүлэг болон насны бүлгээр

(Хүснэгт 6)

Өвчний бүлэг	17–20 нас	21–30 нас	31–40 нас	41–50 нас	51–60 нас	61–70 нас	71+ нас	Нийт
Амьсгалын замын өвчин	39 (12.3%)	8,063 (12.7%)	17,849 (10.8%)	12,775 (8.5%)	7,582 (6.8%)	977 (6.6%)	51 (10.7%)	47,336
Арьсны өвчин	13 (4.1%)	2,109 (3.3%)	4,497 (2.7%)	3,916 (2.6%)	2,730 (2.5%)	323 (2.2%)	5 (1.0%)	13,593
Бусад өвчин	1 (0.3%)	3,096 (4.9%)	9,849 (6.0%)	6,070 (4.0%)	3,914 (3.5%)	681 (4.6%)	28 (5.9%)	23,639
Гэмтлийн өвчин	127 (40.1%)	15,143 (23.9%)	35,911 (21.7%)	31,932 (21.3%)	24,929 (22.5%)	3,676 (24.8%)	109 (22.8%)	111,827
Дотоод шүүрлийн өвчин	0 (0.0%)	244 (0.4%)	1,223 (0.7%)	2,534 (1.7%)	2,802 (2.5%)	328 (2.2%)	3 (0.6%)	7,134
Жирэмслэлттэй холбоотой	16 (5.0%)	9,785 (15.4%)	19,791 (12.0%)	5,075 (3.4%)	65 (0.1%)	0 (0.0%)	0 (0.0%)	34,732
Зүрх судасны өвчин	8 (2.5%)	2,698 (4.3%)	10,326 (6.3%)	15,386 (10.2%)	16,585 (15.0%)	2,672 (18.1%)	77 (16.1%)	47,752
Мэдрэлийн өвчин	9 (2.8%)	2,781 (4.4%)	8,602 (5.2%)	9,657 (6.4%)	6,982 (6.3%)	701 (4.7%)	30 (6.3%)	28,762
Нүд, чих, хамар хоолойн өвчин	4 (1.3%)	847 (1.3%)	2,681 (1.6%)	2,789 (1.9%)	1,907 (1.7%)	250 (1.7%)	8 (1.7%)	8,486
Сэтгэцийн өвчин	2 (0.6%)	468 (0.7%)	2,126 (1.3%)	2,883 (1.9%)	2,343 (2.1%)	273 (1.8%)	3 (0.6%)	8,098
Тодорхойгүй	0 (0.0%)	31 (0.0%)	103 (0.1%)	91 (0.1%)	41 (0.0%)	7 (0.0%)	0 (0.0%)	273
Хавдар, цусны өвчин	1 (0.3%)	1,156 (1.8%)	4,555 (2.8%)	8,762 (5.8%)	8,009 (7.2%)	991 (6.7%)	32 (6.7%)	23,506
Халдварт өвчин	15 (4.7%)	2,046 (3.2%)	3,433 (2.1%)	2,818 (1.9%)	1,918 (1.7%)	301 (2.0%)	6 (1.3%)	10,537
Хоол боловсруулах эрхтний өвчин	34 (10.7%)	5,035 (7.9%)	14,593 (8.8%)	15,781 (10.5%)	11,262 (10.2%)	1,444 (9.8%)	45 (9.4%)	48,194
Шээс, бэлгийн замын өвчин	30 (9.5%)	6,779 (10.7%)	18,771 (11.4%)	16,709 (11.1%)	9,257 (8.4%)	922 (6.2%)	27 (5.6%)	52,495
Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой	9 (2.8%)	1,177 (1.9%)	3,171 (1.9%)	3,134 (2.1%)	2,445 (2.2%)	357 (2.4%)	13 (2.7%)	10,306
Яс, булчингийн өвчин	9 (2.8%)	1,929 (3.0%)	7,718 (4.7%)	9,852 (6.6%)	7,976 (7.2%)	896 (6.1%)	41 (8.6%)	28,421
Нийт	317 (100%)	63,387 (100%)	165,199 (100%)	150,164 (100%)	110,747 (100%)	14,799 (100%)	478 (100%)	505,091



3.2 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийн өвчний бүлэг болон насны бүлгээр харьцуулсан үзүүлэлт

Өвчний бүлгээр авч үзэхэд нийт бичигдсэн эмнэлгийн хуудасны хүйсийн бүтэц өвчний онцлогоос хамааран ялгаатай байна. Гэмтлийн өвчний бүлэгт эрэгтэйчүүдийн эзлэх хувь 53.2 хувьтай байгаа нь бусад өвчний бүлгүүдтэй харьцуулахад өндөр түвшинд байна.


Харин амьсгалын замын өвчин, дотоод шүүрлийн өвчин, мэдрэлийн өвчин, нүд, чих, хамар хоолойн өвчний бүлгүүдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 55.0–59.0 хувийг эзэлж байна.

Шээс, бэлгийн замын өвчин болон хавдар, цусны өвчний бүлгүүдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр бөгөөд тус бүр 74.9 хувь, 71.0 хувийг эзэлж байна.

Зүрх судасны өвчин, арьсны өвчин, сэтгэцийн өвчин, хоол боловсруулах эрхтний өвчин, халдварт өвчин зэрэг бүлгүүдэд хүйсийн харьцаа ойролцоо түвшинд байгаа нь тэнцвэртэй тархалттай байгааг харуулж байна. (Хүснэгт 7)

Эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийн өвчний бүлэг болон насны бүлгээр харьцуулсан үзүүлэлт

Өвчний бүлэг	Эмэгтэй (тоо)	Эрэгтэй (тоо)	Эмэгтэй %	Эрэгтэй %	(Хүснэгт 7) Нийт
Амьсгалын замын өвчин	26,014	21,322	55.0%	45.0%	47,336
Арьсны өвчин	6,840	6,753	50.3%	49.7%	13,593
Бусад өвчин	13,772	9,867	58.3%	41.7%	23,639
Гэмтлийн өвчин	52,334	59,493	46.8%	53.2%	111,827
Дотоод шүүрлийн өвчин	3,976	3,158	55.7%	44.3%	7,134
Жирэмслэлттэй холбоотой	34,732	0	100%	0%	34,732
Зүрх судасны өвчин	24,271	23,481	50.8%	49.2%	47,752
Мэдрэлийн өвчин	16,977	11,785	59.0%	41.0%	28,762
Нүд, чих, хамар хоолойн өвчин	4,736	3,750	55.8%	44.2%	8,486
Сэтгэцийн өвчин	4,097	4,001	50.6%	49.4%	8,098
Тодорхойгүй	135	138	49.5%	50.5%	273
Хавдар, цусны өвчин	16,693	6,813	71.0%	29.0%	23,506
Халдварт өвчин	5,254	5,283	49.9%	50.1%	10,537
Хоол боловсруулах эрхтний өвчин	23,789	24,405	49.4%	50.6%	48,194
Шээс, бэлгийн замын өвчин	39,339	13,156	74.9%	25.1%	52,495
Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой	6,244	4,062	60.6%	39.4%	10,306
Яс, булчингийн өвчин	14,499	13,922	51.0%	49.0%	28,421
Нийт	293,701	211,390	58.1%	41.9%	505,091



3.3 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийн өвчний бүлэг ба тэтгэмжийн мөнгөн дүнтэй харьцуулсан үзүүлэлт

Өвчний бүлгээр авч үзэхэд тэтгэмжийн нийт дүн болон нийгмийн даатгалын сангаас (НДС) олгосон дүн 2022–2024 онд ихэнх өвчний бүлгүүдэд тогтмол нэмэгдсэн байна. Ялангуяа гэмтлийн өвчин, хоол боловсруулах эрхтний өвчин, шээс, бэлгийн замын өвчин, зүрх судасны өвчний бүлгүүдэд нийт тэтгэмжийн дүн өндөр байгаа нь эмнэлгийн хуудасны бичилт олголтын тоотой хамааралтай байна.

Гэмтлийн өвчний бүлэг нийт хугацаанд хамгийн өндөр тэтгэмжийн дүнтэй байж, 2022 онд 9,506.4 сая төгрөг байсан бол 2024 онд 23,209.1 сая төгрөгт хүрч өссөн байна. Үүнтэй зэрэгцэн НДС-гаас олгосон дүн мөн адил нэмэгдсэн байна.

Нийт дүнгээр авч үзвэл 2022–2025 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд олгосон тэтгэмжийн 258,358.0 сая төгрөгийн 123,607.0 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас олгосон бөгөөд энэ нь нийт олгосон тэтгэмжийн зардлын 50 хувийг эзэлж байна. (Хүснэгт 8)

Өвчний бүлгийг олгосон тэтгэмжийн мөнгөн дүнтэй харьцуулсан үзүүлэлт
(нийт, НДС- нийгмийн даатгалын сангаас олгосон, сая.төг)

(Хүснэгт 8)

Өвчний бүлэг	2022 он нийт	2022 он (НДС)	2023 он нийт	2023 он (НДС)	2024 он нийт	2024 он (НДС)	2025 он нийт	2025 оны 10 дугаар (НДС)	Нийт	Нийт (НДС)
Амьсгалын замын өвчин	2,623.9	892.9	5,153.3	1,667.9	6,694.6	2,214.4	6,207.4	2,040.2	20,679.1	6,815.5
Арьсны өвчин	914.8	359.8	1,568.9	555.4	2,062.2	687.8	1,698.4	567.8	6,244.3	2,170.8
Бусад өвчин	6,465.2	1,061.6	372.4	118.6	138.7	81.0	161.5	118.9	7,137.8	1,380.1
Гэмтлийн өвчин	9,506.4	6,205.4	17,826.6	10,946.1	23,209.1	13,986.8	20,806.6	12,781.2	71,348.7	43,919.5
Дотоод шүүрлийн өвчин	513.6	227.3	959.6	385.3	1,194.8	432.7	996.5	405.8	3,664.5	1,451.2
Жирэмслэлттэй холбоотой	1,634.1	558.0	2,619.0	886.4	3,344.5	956.1	3,255.7	858.2	10,853.4	3,258.8
Зүрх судасны өвчин	3,553.5	1,714.2	6,475.2	3,067.4	8,195.2	3,538.2	6,815.2	3,087.1	25,039.1	11,406.9
Мэдрэлийн өвчин	1,922.9	827.4	3,819.5	1,507.3	4,532.3	1,624.4	3,957.2	1,559.4	14,231.9	5,518.4
Нүд, чих, хамар хоолойн өвчин	667.4	376.8	1,190.9	690.5	1,515.5	860.2	1,354.3	803.5	4,728.2	2,731.0
Сэтгэцийн өвчин	604.9	208.9	903.0	288.5	1,347.3	347.6	1,254.4	335.7	4,109.6	1,180.7
Тодорхойгүй	14.6	5.4	25.8	7.5	41.8	15.8	39.6	9.4	121.8	38.1
Хавдар, цусны өвчин	2,693.7	2,142.5	4,314.4	3,391.3	5,245.9	3,979.9	5,144.2	3,908.6	17,398.2	13,422.2
Халдварт өвчин	946.0	682.0	1,645.8	1,053.0	1,937.8	1,135.2	1,950.5	1,093.9	6,480.1	3,964.2
Хоол боловсруулах эрхтний өвчин	3,049.7	1,356.1	5,452.6	2,119.9	7,109.5	2,604.5	6,022.4	2,287.6	21,634.1	8,368.1
Шээс, бэлгийн замын өвчин	3,448.5	1,310.9	6,068.2	2,286.3	7,212.8	2,498.2	6,589.6	2,310.0	23,319.1	8,405.4
Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой	579.4	362.3	1,435.6	888.6	1,986.6	1,160.9	1,871.1	1,195.6	5,872.7	3,607.5
Яс, булчингийн өвчин	2,232.4	983.6	3,765.0	1,499.7	5,052.4	1,818.0	4,445.5	1,667.2	15,495.3	5,968.6
Нийт	41,370.7	19,275.0	63,596.0	31,359.8	80,821.1	37,941.9	72,570.1	35,030.1	258,358.0	123,607.0

Дөрөв. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудасны бичилт олголтоор тэргүүлж буй эдийн засгийн салбарууд

4.1 Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсан шалтгаан ба эдийн засгийн ангиллын харьцуулсан үзүүлэлт

Хөдөлмөрийн чадвар түр алдалтын шалтгаанаар авч үзвэл дийлэнх хувь нь ердийн өвчний шалтгаантай байна. Эрүүл мэндийн байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, боловсролын салбарууд болон төрийн удирдлагын салбаруудад ердийн өвчний эзлэх хувь 87.7–90.1 хувийн хооронд хэлбэлзэж, нийт бичилт, олголтын үндсэн хэсгийг бүрдүүлж байна.

Ахуйн ослын шалтгаанаар уул уурхай, олборлолт, тээвэр, барилга угсралт зэрэг салбаруудад харьцангуй өндөр байна. Тухайлбал, барилга угсралтад ахуйн осол 21.1 хувь, хуурай замын ачаа тээвэрт 19.0 хувь, төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаанд 19.6 хувь, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагаанд 17.9 хувь байна.


Харин төв банкны үйл ажиллагаа, эрүүл мэнд, боловсрол, төрийн удирдлагын салбаруудад ахуйн ослын эзлэх хувь 9.9–12.2 хувьтай байгаа нь бусад өндөр эрсдэлтэй салбаруудтай харьцуулахад доогуур түвшинд байна.

Эдийн засгийн ангиллыг хөдөлмөрийн чадвар
алдсан шалтгаанаар ангилбал

(Хүснэгт 9)

Аж ахуйн нэгж байгууллагын эдийн засгийн ангилал	Ахуйн осол (%)	Ердийн өвчин (%)	Мэргэжлээс шалтгаалсан өвчин,	Нийт
--	----------------	------------------	-------------------------------	------

	үйлдвэрлэлийн осол (%)			
Эмнэлгийн үйл ажиллагаа	4,940 (11.9%)	36,653 (88.1%)	11 (0.0%)	41,605
Хувиараа хөдөлмөр эрхлэгч (Сайн дурын даатгуулагч)	3,507 (11.7%)	26,537 (88.3%)	4 (0.0%)	30,049
Сургуулийн өмнөх болон бага боловсрол олгох үйл ажиллагаа	2,182 (11.3%)	17,132 (88.7%)	2 (0.0%)	19,316
Суурь болон бүрэн дунд боловсрол олгох үйл ажиллагаа	2,083 (11.3%)	16,412 (88.7%)	9 (0.0%)	18,504
Өнгөт металлын бусад хүдэр олборлолт	2,101 (12.3%)	15,032 (87.7%)	0 (0.0%)	17,133
Уул уурхай, олборлолтын туслах бусад үйл ажиллагаа	2,878 (17.0%)	14,012 (82.9%)	11 (0.1%)	16,901
Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагаа	2,493 (17.9%)	11,408 (82.1%)	1 (0.0%)	13,902
Үнэт болон төмөрлөг бус бусад металлын үйлдвэрлэл	1,609 (12.5%)	11,264 (87.5%)	1 (0.0%)	12,874
Төмөр замын зорчигч тээвэр	1,586 (12.6%)	10,972 (87.3%)	4 (0.0%)	12,562
Төрийн удирдлагын үйл ажиллагаа	1,527 (12.2%)	10,975 (87.8%)	4 (0.0%)	12,507
Төв банкны үйл ажиллагаа	1,214 (9.9%)	11,098 (90.1%)	1 (0.0%)	12,314
Хуурай замаар хийгдэх ачаа тээвэр	1,946 (19.0%)	8,268 (80.9%)	5 (0.0%)	10,219
Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа	1,468 (16.1%)	7,624 (83.9%)	0 (0.0%)	9,092
Дээрх ангид ороогүй бусад ашигт малтмалын олборлолт	1,074 (15.0%)	6,100 (85.0%)	2 (0.0%)	7,176
Барилга угсралт	1,372 (21.1%)	5,134 (78.9%)	2 (0.0%)	6,508
Хүнс, ундаа, тамхины бөөний худалдаа	1,135 (18.7%)	4,928 (81.3%)	0 (0.0%)	6,063
Шатахууны жижиглэн худалдаа	841 (14.5%)	4,970 (85.5%)	1 (0.0%)	5,812
Чулуун нүүрс олборлолт	793 (14.0%)	4,873 (86.0%)	2 (0.0%)	5,668
Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа	1,054 (19.6%)	4,323 (80.4%)	1 (0.0%)	5,378



4.2 Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн мөнгөн дүнгийн үзүүлэлтийг эдийн засгийн ангилалтай харьцуулсан үзүүлэлт

Эдийн засгийн салбараар авч үзэхэд эмнэлгийн хуудасны тоо, олгосон дундаж хоног болон олгосон тэтгэмжийн хэмжээ салбар хооронд ялгаатай байна. Эмнэлгийн үйл ажиллагаа, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, боловсролын салбарууд эмнэлгийн хуудасны бичилт олголтын хувь өндөр байна. Эдгээр салбарт олгосон дундаж хоног 8.9–10.5 хооронд хэлбэлзэж байна.

Уул уурхай, олборлолт, эрчим хүч, тээврийн салбаруудад эмнэлгийн хуудасны тоо харьцангуй бага боловч нэг эмнэлгийн хуудсанд ногдох олгосон тэтгэмжийн хэмжээ өндөр байна. Тухайлбал, өнгөт металлын хүдэр олборлолт, уул уурхай, олборлолтын туслах үйл ажиллагаа, үнэт болон төмөрлөг бус металлын үйлдвэрлэлд ажил олгогчоос болон нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэмжийн дүн бусад салбартай харьцуулахад өндөр байна.

Дундаж олгосон хоногийн хувьд хувиараа хөдөлмөр эрхлэгчид, барилга угсралт, хуурай замын ачаа тээврийн салбарууд 10 хоногоос дээш хугацаатай байгаа нь бусад салбаруудтай харьцуулахад урт хугацаатай байгааг харуулж байна. Харин банк санхүү, уул уурхайн зарим салбарт дундаж хоног 7.6–7.8 хоног байна.

Нийт дүнгээр үзэхэд их тоогоор эмнэлгийн хуудас бичигдсэн салбарууд тэтгэмжийн нийт хэмжээгээр давамгайлж байгаа бол эрсдэл өндөртэй, цалин хөлсний түвшин өндөр салбаруудад нэг эмнэлгийн хуудсанд ногдох тэтгэмжийн хэмжээ харьцангуй мөн өндөр байна. Энэ нь салбарын онцлог, ажлын нөхцөлтэй уялдсан бүтэцтэй байгааг харуулж байна. (Хүснэгт 10)

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн мөнгөн дүнгийн үзүүлэлтийг эдийн засгийн ангиллаар

(Хүснэгт 10)

Эдийн засгийн салбар	Эмнэлгийн хуудасны тоо	Дундаж олгосон хоног	Ажил олгогчоос олгосон тэтгэмж (₮)	Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэмж (₮)
Эмнэлгийн үйл ажиллагаа	41,605	9.0	10,515,868,557	9,289,115,541
Хувиараа хөдөлмөр эрхлэгч (Сайн дурын даатгуулагч)	30,049	10.5	9,078,052	11,634,851,912
Сургуулийн өмнөх болон бага боловсрол	19,316	9.0	3,411,797,847	2,756,178,468
Суурь болон бүрэн дунд боловсрол	18,504	8.9	3,881,677,116	3,141,651,885
Өнгөт металлын бусад хүдэр олборлолт	17,133	7.6	7,673,417,497	4,597,967,373
Уул уурхай, олборлолтын туслах үйл ажиллагаа	16,901	9.1	7,212,949,649	6,004,859,192
Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх	13,902	8.8	4,930,594,731	4,159,322,101
Үнэт болон төмөрлөг бус металлын үйлдвэрлэл	12,874	7.6	7,810,496,096	5,039,470,903
Төмөр замын зорчигч тээвэр	12,562	8.3	3,879,986,516	3,004,963,716
Төрийн удирдлагын үйл ажиллагаа	12,507	8.9	3,299,779,389	2,512,137,354
Төв банкны үйл ажиллагаа	12,314	7.8	3,604,008,314	2,348,672,313
Хуурай замын ачаа тээвэр	10,219	10.1	2,950,686,270	2,971,134,363
Төмөр зам, авто замын байгууламж барих	9,092	8.3	3,053,404,346	2,285,864,318
Бусад ашигт малтмалын олборлолт	7,176	8.3	2,695,092,233	2,069,442,923
Барилга угсралт	6,508	10.2	1,676,420,794	1,648,950,776
Хүнс, ундаа, тамхины бөөний худалдаа	6,063	9.6	1,299,318,950	1,218,430,108
Шатахууны жижиглэн худалдаа	5,812	9.3	1,075,410,200	960,337,228
Чулуун нүүрс олборлолт	5,668	8.7	2,454,964,722	1,999,812,646
Гэрээний үндсэн дээрх бөөний худалдаа	5,378	9.1	1,449,764,247	1,289,070,175
Хүнсний төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа	4,911	9.4	897,994,271	718,908,116

4.3 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийн эдийн засгийн ангилал ба өвчний бүлгийн харьцуулсан үзүүлэлт

Эдийн засгийн ангиллаар авч үзэхэд бүх салбарт эмнэлгийн хуудасны дийлэнх нь дотор эрхтний өвчин, гэмтэл, осол, мөн бусад өвчин ангилалд төвлөрч байна. Ихэнх салбарт дотор эрхтний өвчин 28–35 хувийн хооронд хэлбэлзэж, хамгийн өндөр хувийг эзэлж байгаа нь нийт бүтэц дэх гол бүрэлдэхүүн болж байна.

Гэмтэл, ослын эзлэх хувь уул уурхай, олборлолт, барилга угсралт, тээврийн чиглэлийн салбаруудад харьцангуй өндөр түвшинд байна. Тухайлбал, барилга угсралтад 27.3 хувь, хуурай замын ачаа тээвэрт 25.6 хувь, уул уурхай, олборлолтын туслах үйл

ажиллагаанд 24.1 хувь нь гэмтэл, ослын шалтгаантай байна. Харин боловсрол, эмнэлгийн үйлчилгээ зэрэг салбарт энэ үзүүлэлт 17–18 хувьтай байна.

Амьсгалын зам болон халдварт өвчний хувь ихэнх салбарт 9–14 хувийн хооронд хэлбэлзэж, салбар хоорондын ялгаа харьцангуй бага байна. Яс, булчин, үе мөчний өвчин ихэнх салбарт 4–6 хувийн түвшинд байгаа бол уул уурхайтай холбоотой салбаруудад 13–16 хувь хүртэл нэмэгдсэн байна.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн даатгуулагчийн эдийн засгийн ангилал ба өвчний бүлгийн харьцуулсан үзүүлэлт
(Хүснэгт 11)

Эдийн засгийн ангилал	Гэмтэл, осол	Яс, булчин, үе мөч	Амьсгалын зам ба халдварт	Дотор эрхтний өвчин	Жирэмслэлттэй холбоотой	Бусад өвчин	Нийт
Эмнэлгийн үйл ажиллагаа	7,249 (17.4%)	1,841 (4.4%)	4,919 (11.8%)	12,609 (30.3%)	4,838 (11.6%)	10,149 (24.4%)	41,605
Хувиараа хөдөлмөр эрхлэгч (Сайн дурын даатгуулагч)	6,290 (20.9%)	1,765 (5.9%)	2,667 (8.9%)	9,601 (31.9%)	1,736 (5.8%)	7,990 (26.6%)	30,049
Сургуулийн өмнөх болон бага боловсрол	3,433 (17.8%)	890 (4.6%)	2,088 (10.8%)	6,215 (32.2%)	2,220 (11.5%)	4,470 (23.1%)	19,316
Суурь болон бүрэн дунд боловсрол	3,331 (18.0%)	876 (4.7%)	1,883 (10.2%)	5,918 (32.0%)	2,004 (10.8%)	4,492 (24.3%)	18,504
Өнгөт металлын бусад хүдэр олборлолт	3,406 (19.9%)	2,452 (14.3%)	2,444 (14.3%)	4,828 (28.2%)	533 (3.1%)	3,470 (20.3%)	17,133
Уул уурхай, олборлолтын туслах үйл ажиллагаа	4,077 (24.1%)	1,097 (6.5%)	2,035 (12.0%)	5,336 (31.6%)	416 (2.5%)	3,940 (23.3%)	16,901
Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх	3,465 (24.9%)	792 (5.7%)	1,537 (11.1%)	4,583 (33.0%)	506 (3.6%)	3,019 (21.7%)	13,902
Үнэт болон төмөрлөг бус металлын үйлдвэрлэл	2,554 (19.8%)	2,025 (15.7%)	1,919 (14.9%)	3,796 (29.5%)	443 (3.4%)	2,137 (16.6%)	12,874
Төмөр замын зорчигч тээвэр	2,378 (18.9%)	679 (5.4%)	1,481 (11.8%)	4,452 (35.4%)	645 (5.1%)	2,927 (23.3%)	12,562
Төрийн удирдлагын үйл ажиллагаа	2,442 (19.5%)	649 (5.2%)	1,457 (11.6%)	4,090 (32.7%)	931 (7.4%)	2,938 (23.5%)	12,507
Төв банкны үйл ажиллагаа	1,851 (15.0%)	444 (3.6%)	1,710 (13.9%)	3,533 (28.7%)	1,540 (12.5%)	3,236 (26.3%)	12,314
Хуурай замын ачаа тээвэр	2,621 (25.6%)	603 (5.9%)	1,102 (10.8%)	3,446 (33.7%)	213 (2.1%)	2,234 (21.9%)	10,219
Төмөр зам, авто замын байгууламж барих	2,084 (22.9%)	531 (5.8%)	1,249 (13.7%)	2,859 (31.4%)	244 (2.7%)	2,125 (23.4%)	9,092
Бусад ашигт малтмалын олборлолт	1,545 (21.5%)	959 (13.4%)	1,019 (14.2%)	2,171 (30.3%)	89 (1.2%)	1,393 (19.4%)	7,176
Барилга угсралт	1,776 (27.3%)	312 (4.8%)	764 (11.7%)	1,799 (27.6%)	261 (4.0%)	1,596 (24.5%)	6,508
Хүнс, ундаа, тамхины бөөний худалдаа	1,508 (24.9%)	237 (3.9%)	628 (10.4%)	1,771 (29.2%)	571 (9.4%)	1,348 (22.2%)	6,063
Шатахууны жижиглэн худалдаа	1,218 (21.0%)	344 (5.9%)	551 (9.5%)	2,045 (35.2%)	403 (6.9%)	1,251 (21.5%)	5,812
Чулуун нүүрс олборлолт	1,175 (20.7%)	377 (6.6%)	710 (12.5%)	2,012 (35.5%)	101 (1.8%)	1,293 (22.8%)	5,668
Гэрээний үндсэн дээрх бөөний худалдаа	1,381 (25.7%)	260 (4.8%)	630 (11.7%)	1,599 (29.7%)	497 (9.2%)	1,011 (18.8%)	5,378
Хүнсний төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа	1,133 (23.1%)	189 (3.8%)	499 (10.2%)	1,400 (28.5%)	578 (11.8%)	1,112 (22.6%)	4,911

Тав. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудасны бичилт олголттой холбоотой зарим үзүүлэлтүүд

5.1 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичиж олгосон давтамж

2022–2025 онд жил бүр 1–5 удаагийн давтамжтайгаар олгосон эмнэлгийн хуудас зонхилох хувийг эзэлж байгаа бөгөөд 2022 онд 73.4%, 2023–2025 онд 67–69% орчимд тогтвортой байна. 11 удаа ба түүнээс дээш давтамжтай олгосон эмнэлгийн хуудас бүх жилд 7%-иас доош хэвээр байгаа нь өндөр эрсдэл цөөн бүлэгт төвлөрч байгааг илтгэнэ. Иймд бодлогын түвшинд 6–10 ба 11-ээс дээш давтамжтай бүлгийг өвчний шалтгаан, эдийн засгийн салбараар нарийвчлан ялгаж, зорилтот арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас авсан давтамж
(Хүснэгт 12)

Давтамж	2022 он	2023 он	2024 он	2025 он	Нийт (тоо, %)
1–5	81,958 (73.4%)	92,552 (67.6%)	98,517 (68.3%)	77,186 (68.8%)	350,213 (69.3%)
6–10	23,400 (21.0%)	34,375 (25.1%)	35,771 (24.8%)	27,493 (24.5%)	121,039 (24.0%)
11–15	4,710 (4.2%)	7,437 (5.4%)	7,617 (5.3%)	5,542 (4.9%)	25,306 (5.0%)
16–20	1,170 (1.0%)	1,944 (1.4%)	1,722 (1.2%)	1,394 (1.2%)	6,230 (1.2%)

Давтамж	2022 он	2023 он	2024 он	2025 он	Нийт (тоо, %)
21–25	321 (0.3%)	421 (0.3%)	435 (0.3%)	317 (0.3%)	1,494 (0.3%)
26–30	136 (0.1%)	178 (0.1%)	188 (0.1%)	158 (0.1%)	660 (0.1%)
31–40	16 (0.01%)	22 (0.02%)	31 (0.02%)	27 (0.02%)	96 (0.02%)
50+	16 (0.01%)	18 (0.01%)	18 (0.01%)	1 (0.00%)	53 (0.01%)
Нийт	111,727	136,947	144,299	112,118	505,091 (100%)

5.2 Эмнэлгийн хуудас бичиж олгосон тоогоор тэргүүлж буй эрүүл мэндийн байгууллагууд

Эмнэлгийн хуудас бичиж олгосон тоогоор Баянзүрх (22,882; 4.5%), Баянгол (18,503; 3.6%), Сонгинохайрхан (14,393; 2.8%) дүүргүүдийн эрүүл мэндийн төвүүд давамгайлж, нийт олголтын дийлэнх хувийг эзэлж байна.

Аймаг, бүсийн нэгдсэн эмнэлгүүдээс Дархан-Уул (13,075; 2.6%), Орхон БОЭТ (13,040; 2.6%), Дорноговь (8,211; 1.6%) зэрэг нь харьцангуй өндөр үзүүлэлттэй байгаа нь аж үйлдвэрийн төвлөрөл, уул уурхай, тээвэртэй холбоотой хөдөлмөрийн эрсдэлтэй бүс нутгийн хэмжээнд нөлөөлж байх магадлалтай юм.

Хүснэгтээр үзүүлсэн нэр бүхий эрүүл мэндийн 20 байгууллага нь эмнэлгийн хуудасны нийт олголтын 40.5% (206,192)-ийг бүрдүүлж байгаа нь эмнэлгийн хуудасны бичилт тодорхой цөөн байгууллагад өндөр төвлөрөлтэй байгааг харуулж, хүн амын тоо болон анхан шатны тусламжийн ачааллын тэнцвэргүй байдал, үйлчилгээний хүртээмжийн бүсчилсэн ялгааг илтгэнэ. Энэ нь цаашид анхан шатны тусламжийн чадавхийг дүүрэг, бүсийн түвшинд нэмэгдүүлэх, эмнэлгийн хуудасны бичилтийн хяналтыг сайжруулах шаардлагатайг харуулж байна. (Хүснэгт 13)

Эмнэлгийн хуудас бичиж олгосон тоогоор тэргүүлж буй 20 эрүүл мэндийн байгууллага

(Хүснэгт 13)

№	Эрүүл мэндийн байгууллага	Эмнэлгийн хуудас бичиж олгосон тоо	Эмнэлгийн хуудас бичиж олгосон хувь
1	Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв	22,882	4.5
2	Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв	18,503	3.6
3	Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв	14,393	2.8
4	Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг	13,075	2.6
5	Орхон БОЭТ	13,040	2.6
6	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	11,490	2.3
7	Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг	11,057	2.2
8	Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв	10,992	2.2
9	Хан-Уул эрүүл мэндийн төв	10,991	2.2
10	Улсын гуравдугаар төв эмнэлэг	8,783	1.7
11	Гэмтэл согог судлалын үндэсний төв	8,758	1.7
12	УБТЗ-ын Төв эмнэлэг	8,635	1.7
13	Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв	8,561	1.7
14	Дорноговь нэгдсэн эмнэлэг	8,211	1.6
15	Хэнтий - Бор-Өндөр нэгдсэн эмнэлэг	6,900	1.4
16	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг	6,342	1.2
17	Дорнод БОЭТ	5,991	1.2
18	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	5,980	1.2
19	"Эрдэнэт" сувиллын цогцолбор	5,929	1.2
20	Налайх дүүргийн ЭМН	5,679	1.1
Нийт		206,192	40.5
Улсын хэмжээнд нийт бичигдсэн		505,091	100.0

5.3 Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн давтамжаар хамгийн өндөр 20 иргэн ба ажил олгогчийн нэр

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас олон давтамжтайгаар бичүүлсэн даатгуулагчдын 50 орчим хувийг Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газарт ажилладаг иргэд байгаа нь анхаарал татаж буй бөгөөд тухайн эмнэлгийн хуудас нь үндэслэлтэй бичигдсэн эсэх, үйлдвэрийн газарт хөдөлмөрийн аюулгүй байдлын хангуулах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих нь зүйтэй байна. (Хүснэгт 14)

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн давтамжаар хамгийн өндөр 20 иргэн ба ажил олгогчийн нэр

(Хүснэгт 14)

Ажил олгогчийн нэр	Иргэн	ЭХ бичүүлж авсан давтамж тоо
1 Эрдэнэт Үйлдвэр Төүг	Иргэн 1	53
2 Эрдэнэт Үйлдвэр Төүг	Иргэн 2	35
3 Эрдэнэт Үйлдвэр Төүг	Иргэн 3	31
4 Монголын Хог Хаягдлыг Дахин Боловсруулах Үндэсний Холбоо	Иргэн 4	30
5 Сайн Дурын Даатгал	Иргэн 5	29
6 Сайн Дурын Даатгал	Иргэн 6	29
7 Сайн Дурын Даатгал	Иргэн 7	28
8 Эрдэнэс Критикал Минералс Төүг	Иргэн 8	28
9 Эрдэнэт Үйлдвэр Төүг	Иргэн 9	27
10 Эрдэнэт Үйлдвэр Төүг	Иргэн 10	27
11 Монголросцветмет Төүг	Иргэн 11	27
12 Гаалийн Ерөнхий Газар	Иргэн 12	27
13 Эрдэнэт Үйлдвэр Төүг	Иргэн 13	27
14 Рэдпафмонгол	Иргэн 14	27
15 Эрдэнэт Үйлдвэр Төүг	Иргэн 15	27
16 Мах Импекс Прайм	Иргэн 16	26
17 Эрдэнэт Үйлдвэр Төүг	Иргэн 17	26
18 Эрдэнэт Үйлдвэр Төүг	Иргэн 18	26
19 Эрдэнэт Үйлдвэр Төүг	Иргэн 19	26
20 Монголросцветмет Төүг	Иргэн 20	26

5.4 Эмнэлгийн хуудас бичиж олгосон эмч ба ажиллаж буй эрүүл мэндийн байгууллага

Эмнэлгийн хуудас бичиж олгосон давтамжын тоогоор өндөр эмч нарын дийлэнх нь нийслэлийн дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн эмч нар байх бөгөөд Эрдэнэт сувиллын цогцолборын эмчийн бичсэн эмнэлгийн хуудасны тоо, давтамж их байгаа нь анхаарал татаж байна. (Хүснэгт 15)

(Хүснэгт 15)

№	Эрүүл мэндийн байгууллага	Эмчийн нэр	ЭХ бичсэн тоо
1	Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв	Г.У	2,117
2	Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв	Б.Э	1,723
3	"Эрдэнэт" сувиллын цогцолбор	Б.О	1,656
4	Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв	Д.Б	1,429
5	Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төв	Г.М	1,422
6	Сонгинохайрхан нэгдсэн эмнэлэг	Ц.Х	1,241

7 Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв	Г.А	1,145
8 Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв	М.Т	892
9 Хан-уул дүүргийн нэгдсэн эмнэлэг	У.Б	838
10 Хан-уул эрүүл мэндийн төв	М.Б	830
11 УБТЗ-ын төв эмнэлэг	Г.Г	820
12 Хан-уул дүүргийн нэгдсэн эмнэлэг	Б.Т	812

Зургаа. Дүгнэлт

1. Судалгаанд хамруулсан 2022-2025 оны 10 дугаар сарын хугацаанд нийт бичигдсэн хөдөлмөрийн чадвар түр алдсаны 505091 эмнэлгийн хуудасны мэдээллийг нас, хүйс, өвчний бүлэг, эмчилгээний хэлбэр, эдийн засгийн салбар, тэтгэмжийн мөнгөн дүнгийн үзүүлэлтүүдээр авч үзэхэд хөдөлмөрийн чадвар түр алдалт нь цөөн бүлэгт санамсаргүй тархсан бус, харин тодорхой бүтэц, давтамж, төвлөрөлтэй байгааг харуулж байна. Эмнэлгийн хуудасны дийлэнх хэсэг нь 31–50 насанд ногдож, энэ насны бүлэг нь өвчний бүтцийн хувьд гэмтэл, дотор эрхтний өвчин, яс булчингийн эмгэг давамгайлсан шинжтэй байна. Нас ахихын хэрээр зүрх судасны болон хавдар, цусны өвчний эзлэх хувь нэмэгдэж, залуу насанд гэмтэл, амьсгалын замын өвчин харьцангуй өндөр түвшинд байна.
2. Хүйсийн хувьд эмнэлгийн хуудасны нийт бичилт, олголтод эмэгтэйчүүдийн эзлэх хувь тогтвортой өндөр байна. Өвчний бүлгээр авч үзвэл шээс бөөрний замын өвчин, хавдар цусны өвчинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь давамгайлж байгаа бол гэмтэл, осол, зарим халдварт болон амьсгалын замын өвчинд эрэгтэйчүүдийн хувь харьцангуй өндөр байна. Энэ нь хүйсийн ялгааг зөвхөн тоогоор бус, өвчний шинж чанартай уялдуулан тайлбарлах шаардлагатайг харуулж байна.
3. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлбэрийн хувьд амбулаторийн тусламж нийт эмнэлгийн хуудасны 50 хувиас илүүг эзэлж байгаа ч хэвтэн эмчлүүлсэн даатгуулагчын хувь 2022–2024 онд дараалан өссөн нь анхаарал татаж байна. Хэвтэн эмчлүүлсэн эмнэлгийн хуудасны өсөлт нь эмчилгээний хоног, тэтгэмжийн дундаж дүн нэмэгдэхтэй уялдаж, нийт санхүүгийн ачаалалд шууд нөлөөлсөн байна. 2025 оны үзүүлэлт буурсан мэт харагдаж байгаа нь тухайн оны сүүлийн саруудын мэдээлэл бүрэн бус байгаатай холбоотой гэж үзэх нь зүйтэй.
4. Эдийн засгийн салбараар авч үзвэл уул уурхай, барилга, тээвэр, эрчим хүч зэрэг биеийн хүчний ачаалал өндөр, эрсдэлтэй салбаруудад эмнэлгийн хуудасны бичилт өндөр хэвээр байгаа бөгөөд эдгээр салбарт гэмтэл, дотор эрхтний өвчин давамгайлж байна. Харин боловсрол, эрүүл мэнд, төрийн удирдлагын салбарт ердийн өвчний эзлэх хувь өндөр, осол гэмтлийн хувь харьцангуй бага байна. Энэ ялгаа нь салбарын ажлын онцлогтой хамааралтай байх магадлалтай байна.
5. Тэтгэмжийн санхүүжилтийн бүтцэд ажил олгогч болон нийгмийн даатгалын сангийн оролцоо ойролцоо түвшинд хадгалагдаж байгаа бөгөөд нийт дүнгийн хувьд аль нэг эх үүсвэр дангаараа давамгайлаагүй байна.
6. Дүн шинжилгээгээр хөдөлмөрийн чадвар түр алдалт нийтэд жигд тархсан бус, харин хөдөлмөрийн насны тодорхой бүлэг, өвчний тодорхой бүтэц, эдийн засгийн зарим салбарт илүү төвлөрч байгааг харуулж байна. Хөдөлмөрийн орчин, ажлын нөхцөлтэй уялдсан өвчлөл, гэмтэл, ослын асуудал хөдөлмөрийн чадвар түр алдалтад чухал байр суурь эзэлж байгааг илэрхийлж байна. Иймд хөдөлмөрийн чадвар түр алдалтыг бууруулах чиглэлд авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмж олголтоор хязгаарлагдах бус, ажлын байрны аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл ахуй, зонхилох шалтгаан болж буй өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хамарсан цогц үйл ажиллагаа шаардлагатайг харуулж байна.

Долоо. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

1. Дотор эрхтний болон яс, булчингийн өвчний хувьд хөдөлмөрийн нөхцөл, ажлын байрны ачаалалтай холбоотой урт хугацааны эрсдэл хуримтлагдаж байгааг харгалзан эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо, хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх.

2. Эдийн засгийн салбарын ангиллаар ажиглагдсан ялгааг харгалзан эмнэлгийн хуудасны бичилт, олголт ихтэй салбаруудад салбарын онцлогт нийцсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх.
3. Даатгуулагчид эмнэлгийн хуудас бичиж олгох журамд нэмэлт өөрчлөлт оруулж эмч, эрүүл мэндийн байгууллагын хариуцлага, эмнэлгийн хуудас бичиж олгох нөхцөл, шалгуурыг тодорхой болгох.
4. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас олголтоор өндөр, давтамж их байгаа салбар, эрүүл мэндийн байгууллагын эмч нарын бичиж олгосон эмнэлгийн хуудасны үндэслэлд хяналт шалгалт хийж, холбогдох хууль, дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллахад дотоодын хяналтыг эрчимжүүлэх.

ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН ТӨВ ЗӨВЛӨЛ